



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар  
2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ОРА-2021/65/СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2021 он

Орхон аймаг дахь төрийн аудитын газрын захирал бөгөөд

тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70359826 Цахим хаяг: [orkhon@audit.gov.mn](mailto:orkhon@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитор: Д.Мягмарсүрэн

Утас: 99030170 Цахим хаяг: [www.dalaivanaudit.mn](http://www.dalaivanaudit.mn)



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт




## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	11
3.Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	13
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
<b>3.9. Аудитын илрүүлэлт .....</b>	<b>15</b>
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	16
4. Менежментийн захидал .....	17

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

 <b>ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Урт булаг баг, Ханддоржийн гудамж, Утас/Факс: 70359826 Цахим шуудан: orkhon@audit.gov.mn 2021.02.05 № 63 танил _____ -ны № _____ -т	<b>ОРХОН АЙМГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГА С.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА</b>
<b>Аудитын санал дүгнэлт</b>	
<b>Зөрчилгүй дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.</p>	
<b>Дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<b>Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага</b>	
<p>Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.</p>	
<p>Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.</p>	
D:\my doc\albanbichig\ 2021-A4.doc	

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>438,141,334.80</u></b>	<b><u>163,445,243.47</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	370,147,729.00	91,846,955.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	370,147,729.00	91,846,955.00
3351	Байгууллагаас авах авлага	370,147,729.00	91,846,955.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	67,993,605.80	71,598,288.47
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	60,629,700.35	60,629,700.35
35110	Тусгай зориулалттай материал	60,629,700.35	60,629,700.35
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	7,363,905.45	10,968,588.12
35440	Түлш, шатах тослох материал	1,800,800.00	4,841,482.67
35470	Бусад хангамжийн материал	5,563,105.45	5,827,105.45
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>397,739,826.95</u></b>	<b><u>481,528,947.24</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	397,739,826.95	481,528,947.24
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	246,293,160.21	331,762,280.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	74,384,726.49	74,384,726.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,680,537.28	-7,361,074.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	96,127,560.00	125,627,560.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-62,460,893.09	-73,195,615.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	80,193,083.30	100,893,083.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	-61,769,194.32	-66,660,916.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	59,583,378.72	59,583,378.72
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,831,538.55	-42,049,203.45
39214	Бусад үндсэн хөрөнгө	120,156,839.61	190,428,343.37
39215	Хуримтлагдсан элэгдэл	-19,410,264.67	-29,888,001.18
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	151,446,666.74	149,766,666.74
39301	Программ хангамж	21,195,000.00	21,195,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-16,588,333.26	-18,268,333.26
39303	Бусад биет бус хөрөнгө	146,840,000.00	146,840,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>835,881,161.75</u></b>	<b><u>644,974,190.71</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>959,357.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	959,357.00	00.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	959,357.00	00.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	959,357.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	959,357.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>834,921,804.75</u></b>	<b><u>644,974,190.71</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	834,921,804.75	644,974,190.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	258,066,475.95	258,066,475.95
51101	Өмч: - төрийн	258,066,475.95	258,066,475.95



512	Хуримтлагдсан үр дүн	570,146,940.92	380,199,326.88
51210	Өмнөх үеийн үр дүн	570,146,940.92	570,146,940.92
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	6,708,387.88	6,708,387.88
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>835,881,161.75</b>	<b>644,974,190.71</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

### САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>380,133,900.00</b>	<b>1,227,342,174.76</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>39,250,000.00</b>	<b>120,671,503.76</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	39,250,000.00	120,671,503.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	39,250,000.00	120,671,503.76
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250,000.00	200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	39,000,000.00	120,471,503.76
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>340,883,900.00</b>	<b>1,106,670,671.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	247,080,000.00	888,410,471.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	247,080,000.00	884,310,471.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	93,803,900.00	218,260,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,803,900.00	218,260,200.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>225,813,496.20</b>	<b>1,417,289,788.80</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>225,813,496.20</b>	<b>1,417,289,788.80</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	225,623,496.20	1,405,037,387.40
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	67,626,162.00	167,740,713.79
210101	Үндсэн цалин	57,184,940.00	115,327,036.00
210102	Нэмэгдэл	7,768,222.00	44,385,677.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,673,000.00	8,028,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8,453,269.00	20,904,967.81
210201	Тэтгэврийн даатгал	5,748,223.00	14,214,460.37
210202	Тэтгэмжийн даатгал	676,262.00	1,672,405.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	541,009.00	1,337,922.22
210204	Ажилгүйдлийн даатгал	135,251.00	640,543.29
210205	Эрүүл мэндийн даатгал	1,352,524.00	3,039,636.66
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,047,437.56	4,465,218.00
210301	Гэрэл, цахилгаан	806,690.00	1,841,418.00
210302	Түлш, халаалт	695,427.56	1,385,100.00
210303	Цэвэр, бохир ус	598,920.00	1,238,700.00
210304	Байрны түрээс	4,946,400.00	00.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,265,708.50	47,065,031.33





Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	450,000.00	44,625,117.33
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	591,708.50	1,156,464.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,224,000.00	479,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,950,000.00</b>	<b>7,200,000.00</b>
210502	Хоол, хүнс	1,950,000.00	7,200,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,234,600.00</b>	<b>2,544,700.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,234,600.00	2,544,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>108,740,534.00</b>	<b>1,115,084,373.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	107,859,140.00	1,113,297,171.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	163,944.00	207,144.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,450.00	332,058.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	473,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,305,785.14</b>	<b>37,902,383.47</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,364,400.00	1,220,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,941,385.14	36,682,383.47
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>190,000.00</b>	<b>12,252,401.40</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>190,000.00</b>	<b>4,839,988.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	190,000.00	4,839,988.00
213404	Хөрөнгийн		
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>154,320,403.80</b>	<b>-189,947,614.04</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>154,320,403.80</b>	<b>-189,947,614.04</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

СТ-2А

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>341,133,900.00</b>	<b>1,477,018,400.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>250,000.00</b>	<b>200,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	250,000.00	200,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	250,000.00	200,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250,000.00	200,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>340,883,900.00</b>	<b>1,476,818,400.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	247,080,000.00	1,258,558,200.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	247,080,000.00	1,254,458,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	93,803,900.00	218,260,200.00



132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	93,803,900.00	218,260,200.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>262,002,037.06</b>	<b>1,477,018,400.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>262,002,037.06</b>	<b>1,477,018,400.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>261,812,037.06</b>	<b>1,373,012,669.60</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	66,945,117.00	168,793,696.79
210101	Үндсэн цалин	51,082,805.00	116,380,019.00
210102	Нэмэгдэл	11,938,812.00	44,385,677.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,923,500.00	8,028,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	8,368,600.00	20,904,967.81
210201	Тэтгэврийн даатгал	5,690,700.00	14,217,458.37
210202	Тэтгэмжийн даатгал	669,500.00	1,672,405.27
210203	ҮОМШӨ-ний даатгал	535,660.00	1,337,922.22
210204	Ажилгүйдлийн даатгал	133,840.00	334,480.05
210205	Эрүүл мэндийн даатгал	1,338,900.00	3,342,701.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,047,437.56	4,465,218.00
210301	Гэрэл, цахилгаан	806,690.00	1,841,418.00
210302	Түлш, халаалт	695,427.56	1,385,100.00
210303	Цэвэр, бохир ус	598,920.00	1,238,700.00
210304	Байрны түрээс	4,946,400.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	48,142,408.50	52,006,514.00
210401	Бичиг хэрэг	480,000.00	804,050.00
210402	Тээвэр, шатахуун	46,870,700.00	49,466,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	591,708.50	1,156,464.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	479,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	5,550,000.00	7,464,000.00
210502	Хоол, хүнс	5,550,000.00	7,200,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	465,000.00	2,430,000.00
210604	Урсгал засвар	465,000.00	2,130,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,952,140.00	2,544,700.00
210702	Дотоод албан томилолт	5,952,140.00	2,544,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	110,976,934.00	1,113,183,573.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	109,368,190.00	1,111,396,371.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	163,944.00	207,144.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	243,450.00	332,058.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	910,000.00	473,000.00
210807	Газрын төлбөр	67,350.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,364,400.00	1,220,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,364,400.00	1,220,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>190,000.00</b>	<b>104,005,730.40</b>



2132	Бусад урсгал шилжүүлэг	190,000.00	4,839,988.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	190,000.00	4,839,988.00
213404	Хөрөнгийн		
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>79,131,862.94</b>	<b>00.00</b>
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	79,131,862.94	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	79,131,862.94	00.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,066,475.95	2,171,225.00	148,766,721.30	409,004,422.25
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,066,475.95	2,171,225.00	148,766,721.30	409,004,422.25
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	154,320,403.80	154,320,403.80
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,066,475.95	6,708,387.88	570,146,940.92	834,921,804.75
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,066,475.95	6,708,387.88	570,146,940.92	834,921,804.75
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,066,475.95	6,708,387.88	570,146,940.92	834,921,804.75
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-189,947,614.04	-189,947,614.04
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,066,475.95	6,708,387.88	380,199,326.88	644,974,190.71

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,145,211,000.00	1,377,852,657.60
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,145,211,000.00	1,377,852,657.60
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,140,571,000.00	1,373,012,669.60
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	140,901,000.00	168,793,696.79
210101	Үндсэн цалин	96,921,000.00	116,380,019.00
210102	Нэмэгдэл	37,260,000.00	44,385,677.79
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,720,000.00	8,028,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	17,613,000.00	20,904,967.81
210201	Тэтгэврийн даатгал	11,977,000.00	14,217,458.37

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

21020 2	Тэтгэмжийн даатгал	1,409,000.00	1,672,405.27
21020 3	ҮОМШӨ-ний даатгал	1,127,000.00	1,337,922.22
21020 4	Ажилгүйдлийн даатгал	282,000.00	334,480.05
21020 5	Эрүүл мэндийн даатгал	2,818,000.00	3,342,701.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>4,015,000.00</b>	<b>4,465,218.00</b>
21030 1	Гэрэл, цахилгаан	1,535,000.00	1,841,418.00
21030 2	Түлш, халаалт	1,448,000.00	1,385,100.00
21030 3	Цэвэр, бохир ус	1,032,000.00	1,238,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>50,693,700.00</b>	<b>52,006,514.00</b>
21040 1	Бичиг хэрэг	704,900.00	804,050.00
21040 2	Тээвэр, шатахуун	48,558,800.00	49,466,600.00
21040 3	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	929,000.00	1,156,464.00
21040 5	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	101,000.00	100,000.00
21040 6	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	479,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>7,200,000.00</b>	<b>7,464,000.00</b>
21050 2	Хоол, хүнс	7,200,000.00	7,200,000.00
21050 3	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	264,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>600,000.00</b>	<b>2,430,000.00</b>
21060 3	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	300,000.00
21060 4	Урсгал засвар	300,000.00	2,130,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>387,500.00</b>	<b>2,544,700.00</b>
21070 2	Дотоод албан томилолт	387,500.00	2,544,700.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>918,240,300.00</b>	<b>1,113,183,573.00</b>
21080 1	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	916,218,600.00	1,111,396,371.00
21080 2	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
21080 3	Даатгалын үйлчилгээ	360,000.00	207,144.00
21080 4	Тээврийн хэрэгслийн татвар	354,000.00	332,058.00
21080 5	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	55,000.00
21080 6	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	475,000.00	473,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>920,500.00</b>	<b>1,220,000.00</b>
21090 2	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	920,500.00	1,220,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,640,000.00</b>	<b>4,839,988.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,640,000.00</b>	<b>4,839,988.00</b>
21320 9	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,640,000.00	4,839,988.00

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	218,460,200.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	218,260,200.00
13200 1	Орон нутгийн төсвөөс		218,260,200.00
<b>12000 4</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	200,000.00
12000 41	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		200,000.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,164,925,159.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,164,925,159.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,161,925,171.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	44,028,800.00
210402	Тээвэр, шатахуун	44,028,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	7,200,000.00
210502	Хоол, хүнс	7,200,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,110,696,371.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,110,696,371.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,999,988.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,999,988.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,999,988.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,258,558,200.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,258,558,200.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,254,458,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,100,000.00

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга С.Жаргалсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 10-наас 2021 оны 02 дугаар сарын 16–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Бэйкер Тилли Далайван Аудит” ХХК Орхон аймаг дахь салбарын захирал Д.Мягмарсүрэн, аудитор Б.Пүрэвсүрэн, туслах аудитор Б.Энхжин нар Орхон аймгийн төрийн аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймгийн төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн №33 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Байгууллагын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь “Байгалийн нөөц баялгийг хамгаалах, нөхөн сэргээх, орчны экологийн тэнцвэрт байдлыг хамгаалах, хүний амьдрах эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, Байгаль орчны чиглэлээр төрөөс баримталж буй бодлогыг аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх, Байгаль орчны хууль тогтоомжийн биелэлтэд төрийн болон технологийн хяналт тавих, Байгаль орчны мэдээлэл сургалт, сурталчилгаа явуулах, газар нутаг, орон нутгийн онцлогийг харгалзан аялал жуулчлалыг хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгалийн нөөц баялгийг хамгаалах.
- Байгалийн нөхөн сэргээлтийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.
- Байгалийн баялгийг зүй зохистой ашиглуулах.
- Байгалийн баялгийн төлөв байдалд мониторинг судалгаа хийж шаардлагатай арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэх.
- Байгалийн баялгийг зүй зохистой ашиглахад технологийн хяналт тавих.
- Байгаль орчны бохирдолтыг бууруулж хүний амьдрах эрүүл орчныг бүрдүүлэх.
- Байгаль хамгаалах үйлсэд иргэд, байгууллага аж ахуйн нэгжийн оролцоог нэмэгдүүлэх.
- Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, ОНБ, иргэдийн нөхөрлөлүүдэд мэргэжлийн болон арга зүйн туслалцаа үзүүлэх.
- Бүх нийтийн экологийн боловсролыг дээшлүүлэх.
- Орон нутаг аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Байгаль орчны хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж ажиллана.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Байгаль орчин аялал жуулчлалын тухай хууль
- Байгалийн тодорхой баялгийг хариуцан хамгаалах, ашиглах, эзэмших талаар иргэдийн нөхөрлөлийн баримтлах журам

Тайлант хугацаанд гарсан онцлог өөрчлөлт, шинэчлэлт байхгүй.

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Орхон аймаг дахь Санхүү хяналт, аудитын алба 2020 онд Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 451,807.39 мянган төгрөгийн 1 хувиар буюу 4,518.07 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,227,342.17 мянган төгрөгийн 1 хувиар буюу 12,273.42 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 215,147.87 мянган төгрөгөөр буюу 25 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	370,147.73	91,846.95	( 278,300.78 )
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	67,993.6	72,107.4	4,113.8
Үндсэн хөрөнгө	397,739.83	456,778.95	59,039.12
<b>Нийт хөрөнгө</b>	<b>835,881.16</b>	<b>620,733.29</b>	<b>( 215,147.87 )</b>
Өр төлбөр	959.36	0	( 959.36 )
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	834,921.8	620,733.3	( 214,188.5 )
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>835,881.16</b>	<b>620,733.29</b>	<b>( 215,147.87 )</b>



Тайланд оны эцсээр 91,846.95 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй гарсан нь “Стандартын шаардлага хангасан Эко ариун цэврийн байгууламж” байгуулсан иргэдэд урамшуулал олгох дүнгээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 72,107.4 мянган төгрөг болж 4,113.8 мянган төгрөгөөр өссөн нь ковидтой холбоотой гарсан бусад хангамжийн материал нэмэгдсэн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашигладаггүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 456,778.95 мянган төгрөг болж 59,039.12 мянган төгрөгөөр өссөн нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хороо нь МОГ Пластик ХХК-тай 2019 оны 08-р сарын 19-ний өдөр байгуулсан 19/82 дугаартай “Орон нутагт хаягдал хуванцар сав нягтруулан шахах, бутлагч төхөөрөмж суурилуулж хог хаягдлын зохистой менежментийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 02-р сарын 17-ний өдрийн 2020/42 тоот албан бичгээр 20,700.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2020 оны 10-р сарын 15-ны өдөр А/33 тоот тушаалаар 29,500.0 мянган төгрөгөөр “Hager” маркийн тээврийн хэрэгсэл, Орхон аймгийн орон нутгийн өмчийн газрын 2020 оны 06-р сарын 02-ны өдрийн 245 тоот албан бичгээр 25,056.39 мянган төгрөгийн чимээгүй хотод байрлах төмөр торон хашаа, Орхон аймгийн орон нутгийн өмчийн газрын 2020 оны 10-р сарын 02-ны өдрийн 565 тоот албан бичгээр 45,215.11 мянган төгрөгөөр Сархиа уулын хөв цөөрөм зэрэг хөрөнгө нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны 620,733.3 мянган төгрөг болж 214,188.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 469,372.02 мянган төгрөгөөр буюу 27.6 хувиар өссөн бөгөөд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө, нэмэлт санхүүжилтийн орлого өмнөх оноос өссөнөөс шалтгаалсан байна. Харин төсвийн санхүүжилтийн орлого 35,031.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 151,116.8 мянган төгрөгөөр буюу 10.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлсний зардал 33,194.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 5,067.2 мянган төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 178,655.1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 21 хөтөлбөр, арга хэмжээг нэмэлт санхүүжилтийн орлогоор санхүүжүүлэхээр 1,145,211.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Гүйцэтгэлээр нэмэлт санхүүжилтээс 1,258,558.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 218,260.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 200.0 мянган төгрөг нийт 1,477,018.4 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрүүлж урсгал үйл ажиллагаанд 1,377,852.6 мянган төгрөгийг зарцуулж 99,165.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн



бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ИТХ-н 2019 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 15/03 дугаар тогтоолоор Төсөл хөтөлбөр, арга хэмжээний зардалд 803,958.2 мянган төгрөг, Байгаль орчин аялал жуулчлалын яамтай байгуулсан 2020 оны 06 сарын 02-ны өдрийн 20/294 тоот гэрээгээр “Хоггүй цэвэрхэн монгол” арга хэмжээний зардалд 2,100.0 мянган төгрөг, Орхон аймгийн Засаг даргын 2020 оны 06 сарын 30-ны өдрийн А/419 тоот захирамжаар 2019 онд өндөр үнэлгээ авсан байгууллагуудад шагнал олгох 3,000.0 мянган төгрөг, Орхон аймгийн Засаг даргын тамгын газрын 2020 оны 02 сарын 27-ны өдрийн 03/478 тоот албан бичгээр Агаарын бохирдлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор 161,500.0 мянган төгрөг, Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлогын хэлтэс, НҮБ-ын гэрээний дагуу Эко ариун цэврийн байгууламж барьсан иргэдэд урамшуулал олгох 286,000.0 мянган төгрөг, Хоггүй цэвэрхэн монгол аяны хүрээнд Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын 2020 оны 05 сарын 01-ний өдрийн А/324 тоот тушаалаар 2,000.0 сая төгрөг нийт 1,258,558.2 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн орлогыг төвлөрүүлж, төрийн сангаас зарцуулах эрх нээлгэн 1,165,425.15 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 93,133.04 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 1 мэдээлэл, иж бүрэн бус мэдээлсэн 1 мэдээлэл байна. Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын шилэн дансанд хийсэн дотоод аудитын тайлангаар 14.6 сая төгрөгийн худалдан авалтын мэдээг дутуу мэдээлсэн байсныг залруулж нөхөж мэдээлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангаар 1 албан шаардлага, 2 зөвлөмж авсан ба биелэлтийг 2020 оны 06-р сарын 22-ны өдрийн 32 тоот хариу тайлбар ирүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	371,107.0	1	371,107.0	100
Зөвлөмж	2	1,009.6	2	1,009.6	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>372,116.6</b>	<b>3</b>	<b>372,116.6</b>	<b>100</b>

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 207,310.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 191,757.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 953.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 14,600.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлангийн хугацаанд авсан шатахууны урамшуулал 1,597.8 мянган төгрөгийг орлогод авч бүртгэлд тусгаагүй, иргэдэд үнэ төлбөргүй олгосон 160,160.0 мянган төгрөгийн халаалтыг бараа материалын тайланд зарцуулснаар тайлагнасан байсныг аудитын явцад залруулга хийсэн.
2. Орхон аймгийн Засаг даргын 2020 оны 12-р сарын 28-ны өдрийн А/807 дугаар бүхий захирамжаар 30,000.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 5,250.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй авто тээврийн хэрэгслийг шилжүүлсэн боловч бүртгэлээс хасаагүй байсныг аудитын явцад залруулж бүртгэлээс хассан.

### **Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Орхон аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж буй “Стандартын шаардлага хангасан эко ариун цэврийн байгууламж байгуулсан гэр хорооллын иргэдэд урамшуулал олгох” ажлыг гүйцэтгэх явцдаа даргын тушаалгүй, ажлын хэсгийн хүлээж авсан акт, дүгнэлтгүйгээр 5 иргэнд 932,400.0 төгрөгийг урамшуулал хэлбэрээр олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 6.5.4-т “төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах”, Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 596 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтын 2.3-т “Сумдын Засаг даргын Тамгын газар нь эко ариун цэврийн байгууламж байгуулах хүсэлт гаргасан иргэдийг бүртгэх, сонгон шалгаруулах ажлыг нээлттэй, ил тод зохион байгуулж, ажлын гүйцэтгэлд явцын хяналт тавьж ажиллана”, 6.2-т “Эко ариун цэврийн байгууламжийн ажлын гүйцэтгэлийн явцад сумдын ЗДТГ, иргэн, эрх бүхий байгууллага, мэргэжлийн зөвлөх хяналт тавьж ажиллана”, 6.4-т “Ажлын хэсэг нь эрх бүхий байгууллагын дүгнэлтийг үндэслэн эко ариун цэврийн байгууламжийн ажлын гүйцэтгэлийг газар дээр нь шалгаж, эцсийн санхүүжилтийг олгох саналыг санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв

2. ХХОАТ тайланд хөнгөлөлтийг жилийн эцэст өссөн дүнгээр залруулж тохируулга хийгээгүй 20.6 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.14-т “Албан татварын хөнгөлөлтийг энэ хуульд заасан эцсийн хугацаанд тайлагнаж төлсөн албан татварын дүнгээс хэтрүүлэн эдлүүлэхгүй бөгөөд энэ хуулийн 23.1, 23.9-д зааснаас бусад албан татварын хөнгөлөлтийг 28 дугаар зүйлд заасны дагуу буцаан олгоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлангийн жилд анхаарал татахуйц чухал асуудал байхгүй гэж үзэж байна.

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### ***Зардлын данстай холбоотой асуудал***

1. Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд 83 нэр төрлийн 172,037.5 мянган төгрөгийн элэгдлээрээ өртгөө нөхсөн тэг үлдэгдэлтэй ашиглагдаж байгаа хөрөнгүүд бүртгэлтэй байна.
2. Эрсдэл: Холбогдох хууль, тогтоол, журам заавар зөрчсөн байх.
3. Өгсөн зөвлөмж: УСНББОУС үндсэн хөрөнгө 17-ийн 49-д "дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээс материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай" гэсэн заалтын дагуу дахин үнэлгээ хийх шийдвэрийг гаргуулах ба тэг үлдэгдэлтэй ашиглагдахгүй байгаа хөрөнгийг заавар журмын дагуу актлуулах саналыг гаргуулж устгах.
4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн №123 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

##### ***Шилэн данстай холбоотой асуудал***

1. Илрүүлэлт: Тайлант хугацаанд оруулбал зохих 145 мэдээллээс хугацаандаа оруулсан 140 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 1 мэдээлэл, иж бүрэн бус мэдээлсэн 1 мэдээлэл байна. Санхүүгийн хяналт, аудитын албанаас тус байгууллагын шилэн дансанд хийсэн дотоод аудитын тайлангаар 14,600.0 мянган төгрөгийн худалдан авалтын мэдээг дутуу мэдээлсэн байсныг залруулж нөхөж мэдээлсэн байна..
2. Эрсдэл: Шилэн дансны мэдээллийн ил тод байдал алдагдах.
3. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2-т "Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ" гэсэн заалтуудыг дагаж мөрдөж, мэдээллийг цаг хугацаандаа, үнэн зөв, иж бүрэн мэдээлж хэвших..
4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2021 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн №123 тоот албан бичгээр зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа илэрхийлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

Бэлтгэсэн: Аудитор  Б.Пүрэвсүрэн Огноо

Анхан шатанд хянасан: Аудитын менежер  Б.Эрдэнэ Огноо

Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор  Ц.Нармандах Огноо

